

1. ӨМНӨХ ҮГ

1.1. Танилцуулга

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөөнд үйл ажиллагааны гол зорилго, чиглэл ба цар хүрээг тусгасан ба эдгээрийг байгууллагын дүрэмд тусгагдсан байгууллагын зорилго, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн тодорхойлсон.

Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөг байгууллагын дүрэмд нийцүүлэн эрсдэлийн үнэлгээнд суурилан бэлтгэсэн. Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөнд үндэслэн байгууллагын жилийн төлөвлөгөөг бэлтгэх ба энэхүү жилийн төлөвлөгөөнд тухайлсан ажил бүрийн зорилго, цар хүрээ, хугацаа, шаардлагатай нөөц зэргийг харуулсан болно.

1.2. Байгууллагын чиг үүрэг

Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүргийг албаны дүрмээр хүлээн ажиллаж байна.

1.3. Дунд хугацааны төлөвлөгөөг шинэчлэх

Байгууллагын дунд хугацааны төлөвлөгөөг жил бүр хянаж, байгууллагын зорилго, үндсэн чиглэл ба үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтүүд, эрсдэлийн үнэлгээ зэргийг тусгахын тулд байнга шинэчлэнэ. Дунд хугацааны төлөвлөгөөнд хамарсан 2018-2020 оныг дуусгавар болсны дараа дахин үнэлгээг дэлгэрэнгүй байдлаар хийнэ.

Байгууллагын даргын шийдвэрээр дунд хугацааны төлөвлөгөөг зохих байдлаар шинэчилж болох бөгөөд төлөвлөгөөнд хийгдсэн өөрчлөлтүүдийг Дотоод аудитын хороогоор батлуулна.

2. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧОО

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/96 дугаар захирамжаар “Говьсүмбэр аймгийн Санхүүгийн Хяналт, Аудитын Алба” нэртэйгээр 2 оронтоотойгоор байгуулагдсан. Анхны даргаар даргаар М.Ичинноров ажиллаж байсан.


2.1. Байгууллагын эрхэм зорилго

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, эрсдлийн удирдлагаар хангаж, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд манай байгууллагын эрхэм зорилго оршино.

2.2. Байгууллагад гарсан өөрчлөлт

Засгийн Газрын 2014 оны 324 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагч нарын дотоод аудитын албыг, МХЕГ-ын санхүүгийн хяналт шалгалтын газартай нэгтгэн Сангийн Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын шууд удирдлагад шилжүүлсэн шийдвэр гарсан тул аймгийн Засаг даргын 2015 оны 3 дугаар сарын 23-ы А/96 дугаар захирамжаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албыг байгуулсан.

Байгууллагын бүтэц



Байгууллагын дотоод хяналт

Байгууллагын удирдлага нь санхүүгийн хяналт, аудитын ажлыг зохистойгоор хянаж удирдах үүргийг хүлээнэ. Санхүүгийн хяналт аудитын ажлыг хянаж удирдах үйл явц нь аудитын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл ба тайлагнал, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр эргэн хянах зэрэг хяналт шалгалт, аудитын бүх үе шатанд хэрэгжинэ.

Санхүүгийн хяналт, аудитын ажлыг хянаж удирдах үйл явцад дараах үйл ажиллагаанууд багтана.

- ✓ Ажилтан тухайн санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлыг гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, бусад чадвартай эсэхийг харгалзан үзэх
- ✓ Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын төлөвлөлтийн үе шатанд зааварчилгаагаа хангах
- ✓ Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын төлөвлөгөөг хянаж батлах
- ✓ Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажил батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг хянах
- ✓ Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын баримт нь шалгалтаар илэрсэн асуудлууд, дүгнэлт ба зөвлөмжийг хангалттай байхаар дэмжиж байгаа эсэхийг шалгах
- ✓ Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын эхэнд, явцал болон эцэст шалгалтанд хамрагдсан байгууллагын удирдлага ба шалгалтын багийн хоорондын уялдаа, харилцаа зүй зохистойгоор явагдсан эсэхийг авч үзэх
- ✓ Санхүүгийн хяналт шалгалт, аудитын ажлын зорилго хангагдсан эсэхийг хянах

3. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО

Байгууллагын эрхэм зорилго, үндсэн чиглэл болон үйл ажиллагаа, дотоод хяналтын талаарх мэдээлэл дээр үндэслэн байгууллагын 2018-2020 онд хамаарах зорилгуудыг тодорхойлсон.

3.1. Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, байгууллагын хөрөнгө, санхүүгийн бааз суурийг бэхжүүлэх, удирдлага зохион байгуулалтын үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэх

3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, тусгай сангийн үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд эрсдэлд суурилсан дотоод аудит гүйцэтгэн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй зарцуулах талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах

3.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн тусгай зориулалтын сангууд, төсөл хөтөлбөр, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэнд санхүүгийн хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалд хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангуулах, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх

3.4. Албан хаагчдын мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх, чадавхижуулах тасралтгүй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэн мэргэшсэн аудитор, улсын байцаагч бий болгох

3.5. Санхүүгийн хяналт, аудитын дотоод үйл ажиллагаад чанарын баталгаажуулалт хийх, төсвийн шууд захирагчийн дотоод аудитын ажилтан нарыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах

4. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийг үндэслэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн тусгай зориулалтын сангууд, төсөл хөтөлбөр, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд хамаарна.

5. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Тодорхойлсон эрсдлүүд

- ✓ Төсвийн ил тод байдал
- ✓ Санхүү, төсвийн удирдлага
- ✓ Санхүүгийн дотоод хяналт
- ✓ Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт
- ✓ Орлого төвлөрүүлэлт
- ✓ Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалт
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаа
- ✓ Өмнөх хяналт шалгалтын түүх гэсэн 8 үзүүлэлтээр эрсдлийг тодорхойлов.

5.2. Эрсдэлийг хэмжих үнэлэх

Эрсдэлийг хэмжихэд тухайн байгууллагын үйл ажиллагааг 8 шалгуур үзүүлэлтээр 1-10 оноогоор үнэлсэн.



6. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АРГАЧЛАЛ

6.1. Санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудит хийх давтамж

Их эрсдэлтэй: Жилд нэг удаа

Дунд эрсдэлтэй: Хоёр жилд нэг удаа

Бага эрсдэлтэй: гурван жилд нэг удаа

Эрсдэлийн үнэлгээнд үндэсэлэн тухайлсан аудитын ажилд зарцуулах хүн өдрийг тодорхойлсон. Аудитын ажилд зарцуулах хугацааг гаргахдаа өмнөх аудитаар зарцуулсан хугацааг харгалзан үзнэ.

төсөв	Эрсдэлийн түвшингээр		
	их	дунд	бага
1,000,0 сая төгрөгөөс дээш	30-аас доошгүй	25	25
500.0-1,000.0 сая төгрөг	25 хүртэл	20	20

500.0 сая төгрөг хүртэл	20 хүртэл	15 хүртэл	15 хүртэл
-------------------------	-----------	-----------	-----------

Зөвлөмжийн хэрэгжилийн мөрөөр эргэн хянах- Зөвлөмжийн хэрэгжилийн мөрөөр эргэн хянах горимыг хэрэгжүүлэхэд нэг объектод 1-3 хүн/өдөр зарцуулна.

6.2. Хяналт шалгалтын ажил үүргийн хуваарилалт

Байгууллагын ажилтан бүрт ажил үүргийг дараах байдлаар хуваарилна.

- ✓ Нийт хүн-өдрийн 80%-90%-ийг санхүүгийн хяналт, дотоод аудитын баталгаажуулах ажил, дунд хугацааны ба жилийн төлөвлөлтийн ажилд зарцуулах
- ✓ Нийт хүн өдрийн 6%-15%-ийг байгууллагын дотоод үйл ажиллагаанд зарцуулах
- ✓ Нийт хүн өдрийн 4%-5%-ийг мэдлэг, боловсрол дээшлүүлэх сургалт, семинар гэх мэт бусад төрлийн үйл ажиллагаанд зарцуулна.

БОЛОВСРУУЛСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН

АЛБАНЫ ДАРГА:



Н.АЛТАНЦЭЦЭГ